

Стандарт**ЕЗ – Чулуулгийн хүчиллэг урсацыг урьдчилан тооцох,
хянах стандарт**

2008 оны 12 сар

Нууц баримт бичиг

Энэ баримт бичиг нь Рио Тинтогийн ЭМААБО – ны зохиогчийн эрхтэй өмч бөгөөд Рио Тинто Группын компаниудын нууц мэдээлэл агуулсан болно.

© Рио Тинто 2008

Группын үйл ажиллагаа:	Рио Тинто компанийн Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин
Салбар:	Байгаль орчин
Хүчинтэй болох хугацаа:	2009 оны 1 – р сарын 1
Статус:	Эцсийн хувилбар
Хувилбарын дугаар:	2
Баримт бичгийн дугаар:	STE03
Баталсан:	Брюсь Келли
Бэлтгэсэн:	Адриан ван Тондер

Агуулга

Хамрах хүрээ	3
Хөтөлбөрийн ерөнхий бүтэц	4
Хянан засварласан түүх	6

ЕЗ – Чулуулгийн хүчиллэг урсацыг урьдчилан тооцох, хянах

Хамрах хүрээ

Энэ стандартыг Рио Тинто группийн бизнесийн бүх нэгж, группийн удирдан явуулдаг үйл ажиллагааны бүх салбарт баримтлах бөгөөд хэрэв хамаарах бол компанийн/захиргааны албан байр, төслийн талбайн гаднах судалгаа, шинжилгээний барилга байгууламжуудад үүнийг мөрдөнө. Энэхүү стандартын шаардлагуудыг чулуулгийн хүчиллэг урсац үүсгэх ба үүсгэж болзошгүй нөхцөлтэй үйл ажиллагааны бүх салбарт мөрдөнө. Тус стандартад хайгуул судалгаанаас эхлээд бүтээн байгуулалт, зөвшөөрөл авах, олборлолт явуулах, хүдрийн биетийн эрдэсжилт, боловсруулалтын нөхцөл өөрчлөгдөх, уурхайг хаах болон хаасны дараах зэрэг ашигт малтмалын төслийн бүтээн байгуулалтын бүхий үе шатанд хэрэгжүүлэх сульфид агуулагч материал, хүчиллэг урсацад тавих хяналтыг тусгасан болно.

Зорилго: Тус стандарт нь Рио Тинто компанийн төсөл, үйл ажиллагааны салбаруудад тулгарах чулуулгийн хүчиллэг урсацтай холбоотой эрсдлийг бизнесийн бүх үе шатанд үр дүнтэй таних, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлж, нөлөөллийг бууруулж, урт хугацааны зардлыг багасгахын тулд эдгээр эрсдлүүдийг хянан зохицуулах зорилготой юм. Энэхүү стандартыг сульфидийн исэлдлийн бүтээгдэхүүний болзошгүй ялгаралттай холбоотой асуудлуудад мөрдөх бөгөөд үүнд хүчиллэг болон хужирт хөрс, хог хаягдал, шүлт багатай, эсвэл дундаж шүлттэй боловч хүхрийн хүчлийн давс давамгайлсан эрдэсшил, металлын концентрац ихтэй ус ялгарах зэрэг асуудал багтана. Энэ стандартад хэрэглэсэн “чулуулгийн хүчиллэг урсац” гэсэн нэр томъёо нь пирит гэх мэт сульфидийн эрдсүүдийн исэлдлээс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг хамарч байна. Эрсдэлд тухайн цагт нь, тус бурт нь дүн шинжилгээ хийх, хяналтын стратегийг эрт тодорхойлон хэрэгжүүлэх, хяналтыг уулын ажлын төлөвлөлт, ашиглалтын үйл ажиллагаатай нягт уялдуулахад онцгойлон анхаарах хэрэгтэй.

Холбогдох бусад баримт бичиг:

- ЭМААБОЧанарын удирдлагын тогтолцоо (Рио Тинтогийн Бизнес Шийдэл буюу SAP ашигладаггүй салбар компаниудын хувьд E1: Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) стандарт)
- Хариуцлагатай газар ашиглах стандарт
- Эрдсийн гаралтай хог хаягдлын менежментийн стандарт
- Усны хэрэглээ, чанарын хяналтын стандарт
- Уурхайн хаалтын стандарт
- Чулуулгийн хүчиллэг урсацыг урьдчилан тооцох, хянах удирдамж

Хөтөлбөрийн ерөнхий бүтэц

1. Төлөвлөлт

- 1.1 Чулуулгийн хүчиллэг урсац үүсч болзошгүй нөхцөл, урсацын урьдчилсан тооцооны судалгаанд туслах үүднээс хөндөх буюу нөлөөлөлд өртөх сульфид агуулсан чулуулаг, ойр орчмын чулуулгийн бүтэц, сэвсгэр хурдас зэргийн геологийн тогтоц, эрдсийн судалгааг явуулж, баримтжуулсан байна.
- 1.2 Хайгуул судалгаа, далайцын түвшин, Техник эдийн засгийн үнэлгээ болон урьдчилсан үнэлгээ, худалдан авах буюу эзэмшихийн өмнөх тандалт судалгааны ажлын хүрээнд, түүнчлэн үйл ажиллагаа болон эрдэсжилтэд өөрчлөлт оруулахад аливаа шинэ бүтээн байгуулалтын ажлын чулуулгийн хүчиллэг урсац ялгаруулах магадлалын үнэлгээг хийнэ. Чулуулгийн хүчиллэг урсацад хяналт тавих зардлыг бодитойгоор тооцож, төслийн санхүүгийн үнэлгээнд тусгана.
- 1.3 Бүтээн байгуулалтын төсөл эхлүүлэх буюу үйл ажиллагааны салбарыг далайцтайгаар өргөтгөхийн өмнө хүчиллэг урсацын талаарх байгаль орчны зохих суурь судалгаа хийнэ.
- 1.4 Аль нэг төслийг эзэмших эрхийг авч болзошгүй үед хийх тандалт судалгаанд тус төсөлд тулгарч буй болоод тулгарч болзошгүй чулуулгийн хүчиллэг урсацтай холбоотой асуудал, өр төлбөрийн үнэлгээг тусгана.
- 1.5 Сульфид агуулсан доорх материал орон нутгийн өгөршил, эвдрэлийн нөхцөлд урт, богино хугацаанд ямар шинж байдалтай болохыг урьдчилан таамаглах үүднээс чулуулгийн хүчиллэг урсацыг урьдчилан тооцох хөтөлбөр хэрэгжүүлнэ. Үүнд:
 - а) Ил болон далд уурхайд ил гарсан чулуулаг, сэвсгэр хурдсууд;
 - б) Хүдрийн биет, хаягдал чулуулаг, гүний уурхайн блокчилсон олборлолтоос үүссэн хайрга, хүчиллэг хөрс болон хөндөгдсөн бусад материал.
 - в) Хаягдал, овоолон уусгаж, ашиглаж гүйцсэн хүдэр, үйл ажиллагааны явцад гарсан бусад хаягдал чулуулаг.
- 1.6 Хүчиллэг урсацыг урьдчилан тооцох хөтөлбөр нь төсөл буюу санаачилгыг хүлээн авахаас татгалзах эсвэл олборлолт, хаягдлын үр дүнтэй менежментийн стратеги хэрэгжүүлэхээ шийдэж чадахуйц хэмжээнд байх шаардлагатай бөгөөд болзошгүй эрсдэл, өр төлбөрийн талаарх тодорхойгүй байдлыг бууруулсан байна.
- 1.7 Төслийн талбайд хүчиллэг урсацтай холбоотой асуудал байгаа эсэхийг шийдэх анхны үнэлгээ хийх, урьдчилан тооцох хөтөлбөр боловсруулах, гарсан дүнг нь тайлбарлах, менежментийн төлөвлөгөө боловсруулах зэрэг ажилд чулуулгийн хүчиллэг урсацын талаар хүлээн зөвшөөрөгдсөн шинжээчидтэй зөвлөлдөх.
- 1.8 Эрдсийн гаралтай хог хаягдал болон бүтээгдэхүүний хүчиллэг урсац ялгаруулж болзошгүй чанартай тохируулан, хүчиллэг урсацыг урьдчилан тооцох хөтөлбөртэй

нийцүүлж, дараахи асуудлыг тусгасан “Чулуулгийн хүчиллэг урсацыг хянах төлөвлөгөө” боловсруулна. Үүнд:

- а) Чулуулгийн хүчиллэг урсацын орчин, аюул осол, болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээний хураангуй;
- б) Хаяж, зайлуулах арга хэмжээний хил хязгаар, мөрдөх байгаль орчны шаардлагууд;
- в) Ашиглалтын явцад болон уурхайг хаасны дараа найдвартай, зардалд хэмнэлттэй байдлаар байгаль орчны зорилтуудыг биелүүлэхэд зориулан боловсруулсан Чулуулгийн хүчиллэг урсацыг хянах стратеги;
- г) Тус хяналтын төлөвлөгөөг тухайн газар орны нөхцөл байдалд тууштай хэрэгжүүлэх журам, ажил үүргийн хувиарлалт;
- д) Чулуулгийн хүчиллэг урсацын шинж чанарыг тодорхойлох, хяналт шинжилгээний ажлын явуулах, мэдээлэл тасралтгүй цуглуулах шаардлага;
- е) Төлөвлөгдөөгүй нөхцөл байдал, урьдаас тааварлаагүй нөлөөлөл бий болоход авч хэрэгжүүлэх арга хэмжээ

2. Хэрэгжилт ба Ашиглалт

- 2.1 Уурхайн олборлох, боловсруулах үйл ажиллагааны төсөл, чулуулгийн хаягдлын хуваарь гаргах ажил, уурхайг хаах төлөвлөгөө, үйл ажиллагааны холбогдох журам болон бизнес төлөвлөгөөтэй нягт уялдуулах байдлаар Чулуулгийн хүчиллэг урсацыг хянах төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- 2.2 Уурхайгаас олборлон гаргасан хүчиллэг урсац үүсгэх, бууруулах чадвараасаа хамааран агаарын исэлдүүлэгчийн нөлөөнд өртсөн материалын тоо хэмжээ, байршил, нийтлэг шинж чанарын талаарх мэдээллийг багтаасан бүртгэл хөтлөх.
- 2.3 Чулуулгийн хүчиллэг урсацыг урьдчилан тооцоолох хөтөлбөр хэрэгжүүлэх, урсацыг хянах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагыг нөлөөлөлд өртсөн үйл ажиллагааны салбар бүрт оногдуулах.
- 2.4 Тухайн үйл ажиллагааны салбарын хувьд хүчиллэг урсац томоохон асуудал болох бол сургалт, зааварчилгаа, ерөнхий ойлголт бий болгох болон ажлын байрын тусгай сургалтуудад чулуулгийн хүчиллэг урсацын эрсдэл, эрсдлийг хэрхэн хянах талаар тайлбарлах нэмэлт мэдээлэл тусгана. Үйл ажиллагааны ийм салбаруудын удирдлагын баг чулуулгийн хүчиллэг урсацаас урьдчилан сэргийлэх, хянах зохих мэдлэгтэй байх шаардлагатай.

3. Ажлын гүйцэтгэлийн хэмжилт

- 3.1 Чулуулгийн хүчиллэг урсацын үүсгэж болзошгүй сөрөг нөлөөлөлд тохирсон хяналт шинжилгээний журамтай байж, тус журмаар үл зөвшөөрөгдөх нөлөөллийн талаар эртнээс зохих байдлаар анхааруулж сэрэмжлүүлэх, дээд удирдлагын шийдвэрийг

хөхүүлэн дэмжиж, өнөөгийн урьдчилан тооцох хөтөлбөрийг дэмжин, хяналтын төлөвлөгөөнд ашигласан таамаглалуудыг баталгаажуулдаг байх шаардлагатай.

- 3.2 Чулуулгийн хүчиллэг урсацыг хянах төлөвлөгөөнд хөндлөнгийн шалгалт явуулах ажлыг тогтмол (хамгийн багадаа 4 жил тутам эсвэл үйл ажиллагаа, байгаль орчны нөхцөл байдлын шаардлагаар илүү олон давтамжтайгаар) зохион байгуулах. Чулуулгийн хүчиллэг урсацын шинжээч тус шалгалтыг явуулж, хэрэгжүүлж буй урьдчилан тооцох хөтөлбөр, хянах стратегийн төлөв байдлыг дүгнэж, үйл ажиллагааны салбар болон Рио Тинто Группэд тулгарч болзошгүй аливаа аюул, эрсдлийг тодорхойлсон хөндлөнгийн баримт бичиг боловсруулан гаргах шаардлагатай.

4. Хянан засварласан түүх

Хувилбар	Хүчинтэй болох огноо	Бэлтгэсэн	Баталсан	
1	2005 оны 6 сар	Аделино Табоада	Гүйцэтгэх удирдлагуудын зөвлөл	
Хувилбар	Хянан засварласан огноо	Хянан засварласан	Баталсан	Өөрчлөлт оруулсан шалтгаан
2	2008 оны 12 сар	Адриан ван Тондер	Брюсь Кэлли	Ашиглалтын багаас өгсөн зөвлөмжийг тусгаж, ЭМААБОЧ – ын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн өөрчилсөн.
	2012 оны 10 сар	Мани Далтерио		Оюу Толгойн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх зорилгоор лого-г хамтатгав. Агуулгад өөрчлөлт оруулаагүй болно.